

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код. 13.020.30

Байгаль орчны удирдлага - Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээ – Арга зүйн заавар	MNS ISO 14031: 2001
Environmental management – Environmental performance evaluation – Guidelines	

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2001 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2001 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандарт нь зөвлөмжийн шинжтэй байна.

1. Хамрах хүрээ

Олон улсын энэ стандарт нь тухайн байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээг хэрхэн явуулах, энэ талаар аргачилсан заавар өгнө. Энэ стандартыг төрөл, хэмжээ, байрлалаас үл хамааран аливаа байгууллага хэрэглэж болно.

Энэ стандартаар байгууллагын байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн төвшинг тогтоохгүй. Баталгаажуулалт, бүртгэлийн зорилгоор эсвэл бусад байгаль орчны удирдлагын тогтолцооны тохирох шаардлагыг тогтооход хэрэглэхгүй.

2. Нэр томъёо, тодорхойлолт

Олон улсын энэ стандартад дараахь нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

2.1

Байгаль орчин

Тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хүрээлэл, үүнд: агаар, ус, хөрс, байгалийн баялаг, ургамал, амьтны аймаг, тэдгээрийн харилцан үйлчлэл

Тайлбар:

“Хүрээлэл” гэдэг нь энэ эх бичвэрт дурдсан агуулгаараа тухайн байгууллагын хүрээллээс даяарчлалын тогтолцоонд хамаарна.

2.2

Байгаль орчны асуудал

Байгаль орчинтой харьцах тухайн байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг

Тайлбар:

“Байгаль орчинд хор уршигтай асуудал” гэдэг нь түүнд хортойгоор нөлөөлж буй эсвэл нөлөөлж болзошгүй байгаль орчны асуудлыг хэлнэ.

2.3

Байгаль орчны нөхцөл байдлын заагч (Indicator)

Орон нутгийн, бүс нутгийн, үндэсний, дэлхийн хэмжээний байгаль орчны тухай мэдээллээр хангах онцлог илэрхийлэл

MNS ISO 14031:2001

.....
i), -indicator гэсэн үгийг заалт, заагч, байрлал гэж орчуулж болно.

Тайлбар:

“ Бүс нутаг “ гэдэг нь улс, муж, улс орнуудын бүлэг эсвэл байгууллагын сонгосон шийдвэр нь байгаль орчны нөхцөл байдлаас хамаарсан тив, улс орнуудын бүлэг байж болно.

2.4

Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээнээс шалтгаалан байгаль орчинд үзүүлэх эерэг, сөрөг, (хэсэгчилсэн буюу бүхэлдээ) өөрчлөлт

2.5

Байгаль орчны удирдлагын тогтолцоо

Орчны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хангах, дүн шинжилгээ хийхэд чиглэсэн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны төлөвлөлт, үүрэг, туршлага, журам, үйл явц болон нөөцийн асуудлыг багтаасан удирдлагын ерөнхий тогтолцооны хэсэг

2.6

Байгаль орчны зорилго

Байгууллага өөрийн бодлогын хэмжээнд тавьж, хүрэхээр төлөвлөж буй байгаль орчны ерөнхий зорилт, энэ нь боломжтой үед тоон утгаар илэрнэ.

2.7

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэл

Байгаль орчны асуудалтай холбоо бүхий байгууллагын удирдлагын үйл ажиллагааны үр дүн.

Тайлбар1:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийг энэ стандартад ISO 14001:1996, ISO 14004:1996-д зааснаас өөрөөр тодорхойлсон.

Тайлбар 2:

Энэ утгаараа, тухайн байгууллага байгаль орчны бодлого, зорилго, төлөвлөгөөт үзүүлэлтийг байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлээр хэмжиж болно.

2.8

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн шалгуур

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх зорилгоор ашиглах, байгууллагын удирдлагын гүйцэтгэх БОНБГ-ийн бусад шийдвэрлэх үе шат болон байгаль орчны бодлого, төлөвлөгөөт үзүүлэлт.

2.9

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээ (БОНБГҮ)

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн шалгууртай холбоо бүхий мэдээллийг үнэлж дүгнэх, тайлагнах, харилцан мэдээлэх, давтагдах дүн шинжилгээ хийх, энэ үйл явцыг сайжруулах, өгөгдлийг шинжлэх, цуглуулах, заагчийг сонгох, байгууллагын байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийг үнэлэх талаар удирдлагын шийдвэрлэх ажиллагаа.

2.10

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн заагч

Байгууллагын байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн тухай мэдээллээр хангахуйц онцлог илэрхийлэл

2.10.1**Удирдлагын гүйцэтгэлийн заагч**

Байгууллагын БОНБГ-д нөлөөлөх удирдлагын хүчин чармайлтын тухай мэдээллээр хангахуйц байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэл заагч.

2.10.2**Ажиллагааны гүйцэтгэлийн заагч**

Байгууллагын үйл ажиллагааны БОНБГ-ийн тухай мэдээллээр хангахуйц байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэл заагч.

2.11**Байгаль орчны бодлого**

Байгаль орчны зорилго, төлөвлөгөөт үзүүлэлтээ тогтоох ажиллагааны хүрээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлтэй холбоотой тухайн байгууллагын зорилт, зарчим.

2.12**Экологийн төлөвлөгөөт үзүүлэлт**

Гүйцэтгэлийн шаардлагыг боломжтой болон тохиромжтой тохиолдолд тоон утгаар илэрхийлэх бөгөөд орчны зорилгоос үүдэх зорилтыг биелүүлэхэд чиглүүлнэ.

2.13**Сонирхогч тал**

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийг явуулахад нөлөөлөгч буюу сонирхогч хэсэг бүлэг эсвэл хувь хүн.

2.14**Байгууллага**

Өөрийн үйл ажиллагаа, удирдлагатай улсын буюу хувийн компани, нэгтгэл, пүүс, үйлдвэр, аж ахуйн нэгж, эрх бүхий байгууллага буюу алба эсвэл тэдгээрийн хослол.

Тайлбар:

Нэг эсвэл түүнээс олон үйл ажиллагааны нэгжийг байгууллагын хэмжээнд авч үзэж болно

3 Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээ**3.1 Ерөнхий тойм****3.1.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үйл явцын загвар**

БОНБГҮ гэдгийг БОНБГ-ийн шалгуур бүхий БОНБГ-ийн өмнөх болон одоогийн харьцуулсан мэдээллээр хангах заагчийг ашиглан явуулах удирдлагын дотоод үйл явц гэж хэлнэ. Олон улсын энэ стандартад БОНБГҮ-г **“Төлөвлө-Хий-Шалга-Ажилла, арга хэмжээ ав”** гэсэн удирдлагын загварыг мөрдлөг болгож нарийвчлан заасан.

Энэ явуулах үйл явцын үе шат нь:

а) Төлөвлө

- 1) Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийг төлөвлөх

MNS ISO 14031:2001

2) Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн заагчийг сонгох (Заагчийг сонгох үйл явцад шинэ заагчийг хэрэгжүүлэх, гарч буй заагчаас сонгох зэргийг багтаана.)

б) Хий

Дор заасан өгөгдөл, мэдээллийг ашиглах:


- 1) Заагчийг сонгохтой холбоотой өгөгдөл цуглуулах
- 2) БОНБГ-д заасан мэдээллийг өгөгдөлд хувиргах, шинжилгээ хийх
- 3) БОНБГ-ийн шалгууртай харьцуулж байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлд заасан мэдээллийг үнэлэх
- 4) БОНБГ-д заасан мэдээллийг тайлагнах, харилцан мэдээлэх

в) Шалга, ажилла, арга хэмжээ ав

БОНБГ-ийг хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх

1-р зураг

Олон улсын энэ стандартын уг бүлэгт хамаатай гарчиг, тоо, тайлбар бүхий БОНБГҮ-ний тухай дараахь зургаас үзнэ үү.



1- р зураг - Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээ

3.1.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээний заагч

Олон улсын энэ стандартад БОНБГҮ-ний заагчийн үндсэн хоёр ангилал байхаар заасан. Үүнд:


- Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн заагч
- Байгаль орчны нөхцөл байдлын заагч

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн заагч нь хоёр төрөлтэй.

- Удирдлагын гүйцэтгэлийн заагч гэж аливаа байгууллагын үйл ажиллагаан дахь БОНБГ-д нөлөөлөх удирдлагын хүчин чармайлтын тухай мэдээллээр хангахуйц БОНБГ-ийн заагчийн төрлийг,
- Ажиллагааны гүйцэтгэлийн заагч гэж байгууллагын үйл ажиллагаан дахь БОНБГ-ийн тухай мэдээллээр хангахуйц БОНБГ-ийн заагчийн төрлийг тус тус хэлнэ.

Байгаль орчны нөхцөл байдлын заагч нь байгаль орчны тухай холбогдох мэдээллээр хангана. Энэ мэдээлэл нь байгаль орчны авч үзэх асуудлын бодит болон боломжит нөлөөг илүү сайн ойлгоход, тухайн байгууллагад түүний нөлөөллийн гүйцэтгэлийг төлөвлөж, хэрэгжүүлэхэд дэмжлэг болно.

Байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, шийдвэр нь түүний үйл явцын гүйцэтгэлтэй нягт хамааралтай.




2-р зурагт эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдэд хамааралтай БОНБГҮ-ний заагчийн төрөл, байгаль орчны нөхцөл байдал, байгууллагын удирдлага, үйл явцын хоорондын дотоод уялдааг үзүүлсэн.

Түлхүүр

Мэдээллийн суваг:

Байгууллагын үйл ажиллагаанд хамаарагдах оролт, гаралтын суваг
Шийдвэрлэх суваг



2-р зураг- Байгаль орчны нөхцөл байдал, байгууллагын удирдлага, үйл явцын хоорондын дотоод уялдаа

3.1.3 Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээг хэрэглэх

БОНБГ-ийг хэрэгжүүлэхэд удирдлагын үүрэг чухал. БОНБГҮ-г төрөл, хэмжээ, байрлалаас үл хамааран аливаа байгууллага гүйцэтгэнэ. БОНБГҮ нь байгууллагын болон бизнесийн үйл ажиллагааны хэсгүүдэд үнэ цэнэтэй байх болно.

БОНБГҮ-нд өгөгдсөн мэдээлэл байгууллагад дараахь байдлаар тус болно:

- БОНБГ-ийн шалгуурт нийцүүлэх шаардлагатай арга ажиллагааг тодорхойлох;
- Байгаль орчны сөрөг нөлөөлөлтэй асуудлыг тогтоох;
- Байгаль орчны асуудлыг илүү сайн удирдах боломжийг тогтоох (өөрөөр хэлбэл бохирдлоос урьдчилан сэргийлэх);
- БОНБГ-ийн чиг хандлагыг тогтоох;
- Үйл ажиллагааны ашиг орлого, үр нөлөөг нэмэгдүүлэх;
- Тохиромж сайтай стратегийг тогтоох;

Тухайн байгууллагын БОНБГ-д өгөгдсөн дотоод тайлан, харилцан мэдээлэл нь түүнийг хариуцлагатай гүйцэтгэхэд ажиллагсдад туслах ба ингэснээр БОНБГ-ийн шалгуурт хүрэх боломжтой болно. Удирдлагаас бусад сонирхогч талуудад мэдээллийг хүргэж, тайлагнаж болно.

Тухайн байгууллагын БОНБГҮ нь түүний гүйцэтгэлийг сайжруулах боломжийг тогтоож, хяналт- шинжилгээг хуваарийн дагуу хийнэ.

3.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээг төлөвлөх (Төлөвлөлт)

3.2.1 Ерөнхий заавар

Тухайн байгууллага БОНБГҮ-г (БОНБГҮ-нд зориулсан заагчийн сонголтыг оролцуулан) төлөвлөнө:

- Орчны нөлөөлөлд хяналт тавьж болох байгаль орчны ач холбогдолтой асуудал;
- БОНБГ-ийн шалгуур ;
- Сонирхогч талуудын үзэл бодол;

Тайлбар:

Олон улсын энэ стандартын А.2 бүлэгт БОНБГҮ-нд сонирхогч талууд дүн шинжилгээ хийх талаар тодорхойлж өгсөн болно.

Тухайн байгууллага БОНБГҮ-г төлөвлөхдөө дараахь асуудлыг авч үзнэ. Үүнд:

- Тухайн байгууллагыг үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр нь ангилах;
- Тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтэц;
- Бизнесийн ерөнхий стратеги;
- Байгаль орчны бодлого;
- Хууль, бусад шаардлага, түүний хэрэгцээт мэдээлэл;
- Байгаль орчны талаархи олон улсын холбогдох хэлэлцээр;
- Байгаль орчны өртөг зардал, ашиг тус;
- БОНБГ-тэй холбоо бүхий санхүүгийн нөлөөг шинжлэхэд шаардлагатай мэдээлэл;
- БОНБГ-тэй холбоотой жилээс жилд өсөн нэмэгдэх тогтмол мэдээллийн хэрэгцээ;
- Орон нутгийн, бүс нутгийн, улс орны болон дэлхий дахины байгаль орчны нөхцөл байдал;
- Нийгэм, соёлын хөгжлийн хүчин зүйл.

БОНБГҮ-г явуулахад шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг удирдлага тогтооно. БОНБГҮ-ний эхний хамрах хүрээ нь нөөц, хэрэгсэл, бодит боломжоос хамаарч удирдлагын гүйцэтгэх үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийг хязгаарлаж болно. БОНБГҮ-ний эхний хамрах хүрээнд тухайн байгууллагын урьдчилан чиглүүлээгүй үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийг чиглүүлэн өргөжүүлж болно.

Тухайн байгууллагын байгаль орчны асуудлыг тогтоож, БОНБГҮ-г төлөвлөх үед оролтын урсгал чухал. Энэ нийтлэг чанартай мэдээлэл нь байгаль орчны удирдлагын тогтолцоонд уялдаатай. Байгаль орчны удирдлагын тогтолцоотой холбогдуулан байгаль орчинд сөрөг нөлөөтэй асуудлыг тогтоох зааврыг ISO 14001, ISO 14004 (Ном зүй үз) стандартад зааж өгсөн.

Байгаль орчны удирдлагын тогтолцоотой байгууллага нь БОНБГҮ, түүнчлэн байгаль орчны бодлого, зорилго, төлөвлөгөө, бусад БОНБГ-ийн шалгуурыг үнэлнэ.

Байгаль орчны удирдлагын тогтолцоогүй байгууллага байгаль орчны асуудлыг тогтоон, сөрөг нөлөөллийг хэлэлцэж, БОНБГ-ийн шалгуурыг бий болгосноор БОНБГҮ-г хэрэглэж чадна. Байгууллагаас байгаль орчны чухал асуудлыг тодорхойлж шийдвэрлэхдээ дараахь зүйлийг анхаарна:

- Материалын гарал үүсэл, хэмжээ, эрчим хүч ашиглалт;

MNS ISO 14031:2001

- Эрчим хүч;
- Эрсдэл;
- Орчны нөхцөл байдал;
- Үйл явдлын боломжтой байдал;
- Хууль тогтоомж, норматив, байгууллагад хамааралтай бусад шаардлага.

Бараг бүх байгууллага нь байгаль орчны асуудлаархи дүн шинжилгээг А.1-р зурагт үзүүлсэн шиг өөрсдийн үйл ажиллагааг төвлөрүүлнэ.

Практик зөвлөгөө ¹ 1.

Байгаль орчны удирдлагын тогтолцоог бүрдүүлээгүй байгууллагад байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлтэй холбоо бүхий асуудал, тэдгээрийн сөрөг нөлөөллийн хандлагыг тогтоох жишээ

- Байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, байгаль орчны онцгой асуудал, түүнтэй холбоотой сөрөг нөлөөллийг тогтоох;

Орчны онцлог нөхцөл байдалд нөлөөлж болох байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтооход байгаль орчны нөхцөл байдлын тухай мэдээллийг ашиглах;

- Байгууллага ашиглах материал, эрчим хүч, ашигласан эрчим хүч, эрчим хүчний

Практик зөвлөгөө ¹1. (Үргэлжлэл)

- Байгууллагын байгаль орчинд сөрөг нөлөөтэй асуудлыг тогтооход эдгээр мэдээллийг ашиглах, сонирхогч талуудын үзэл бодлыг нэгтгэн боловсруулах;

- Байгууллагын цуглуулсан өгөгдөл дэх байгаль орчны хууль тогтоомж болон бусад шаардлагад тохирох байгууллагын үйл ажиллагааг тогтоох;

- Байгууллага нь бүтээгдэхүүн, түүний байгаль орчны нөлөөллийг боловсруулалт, үйлдвэрлэл, үйлчилгээ, хуваарилалт, ашиглалт, дахин ашиглалт, дахин боловсруулалт, хаягдал зэрэгтэй хамтад нь авч хэлэлцэх;

- Байгууллагын байгаль орчны үйл ажиллагааны өртөг зардал, ашиг тусыг тогтоох.

Байгаль орчны удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн эсвэл бүрдүүлээгүй байгууллага БОНБГ, түүнд хамаарах шалгуурыг хэрэглэн БОНБГҮ-ний сонгосон заагч эсвэл БОНБГ-ийн шалгууртай холбоотой БОНБГҮ-г төлөвлөнө.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн шалгуурын эх сурвалжийн жишээнд дараахийг оруулж болно. Үүнд:

- Хийгдсэн болон хийгдэж буй гүйцэтгэл;
- Хуулийн шаардлага;
- Хүлээн зөвшөөрсөн дүрэм , сайн туршлага;
- Үйлдвэр болон бусад салбарын байгууллагын боловсруулсан мэдээлэл, гүйцэтгэлийн өгөгдөл;
- Удирдлагын үзлэг шалгалт болон аудит;
- Сонирхогч талуудын үзэл бодол;
- Нийгмийн судалгаа.

3.2.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээний заагчийг сонгох

3.2.2.1 Ерөнхий заавар

Байгууллага ойлгомжтой, ашигтай чанарын болон тооны өгөгдөл, мэдээллийг харуулахуйц БОНБГҮ-ний заагчийг сонгоно. Эдгээр нь байгууллагын байгаль орчны нөхцөл байдал, байгууллагын үйл ажиллагааны БОНБГ болон БОНБГ-д нөлөөлөх удирдлагын хүчин чармайлтын тухай өгөгдлийг мэдээлэлд хувиргахад туслана. Байгууллага БОНБГ-ийг үнэлэхэд ач холбогдолтой ойлгомжтой заагчийг сонгоно. БОНБГҮ-ний сонгосон заагчид байгууллагын үйл ажиллагааны байдал, цар хүрээг тусгаж болно. Өгөгдлийг тодорхойлох БОНБГҮ-ний заагчийн сонголтыг ашиглана. Эдгээр хүчин чармайлтын үед байгууллага өөрийн болон бусдын цуглуулсан үнэн бодитой өгөгдөлийг ашиглахыг хүснэ.

БОНБГҮ-ний заагчид заасан мэдээллийг хавсралтад заасан мэдээлэл, хамаарах арга хэмжээ, чиглэлээр илрүүлнэ. БОНБГҮ-ний заагчийг мэдээлэлд ашиглах ба үүнийг төлөвлөхөд нөлөөлж, нэгтгэж болно. Нөлөөлж, цуглуулснаар түүнийг ойлгох, нийцүүлэх, харьцуулах, тогтвортой байлгахад анхаарна. Ингэснээр БОНБГҮ-ний заагч, түүнийг мэдээлэл рүү хувиргах болон өгөгдлийн тухай ойлгох болно.

Практик зөвлөгөө ¹ 2.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээний заагчийн үзүүлэлтийн жишээ:

- Шууд хэмжилт, тооцоо: Гарах бохирдлын хэмжээ зэрэг үндсэн өгөгдөл, мэдээлэл;
- Хамаарах хэмжилт, тооцоо: Үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнээс гарах бохирдол, худалдааны нэгж эргэлтээс гарах бохирдол зэрэг харьцуулсан өгөгдөл, мэдээлэл эсвэл хамаарах бусад магадлуур (үйлдвэрлэлийн түвшин, хугацаа, байрлал, нөхцөл);
- Жагсаасан: Суурь жилд гарах бохирдолын хувь хэмжээгээр илэрхийлсэн тухайн жилд гарах бохирдол зэрэг нийт эсвэл сонгож авсан стандартад хамаарах мэдээллийн хэлбэр болон нэгжид хувиргасан мэдээлэл, өгөгдлийг үзүүлэх;
- Цуглуулсан: Бүтээгдэхүүн үйлдвэрлэх олон нөхцөл байдлаас болон тухайн жилд үйлдвэрлэх бүтээгдэхүүнээс гарах бохирдлын нийт хэмжээ зэрэг ижил төрлийн өгөгдөл, мэдээлэл, мөн янз бүрийн эх сурвалжаас авсан, цуглуулсан, ач холбогдол бүхий өгөгдөл, мэдээлэл;
- Нөлөөлсөн: Өгөгдөл, мэдээллийг ач холбогдолтой салбарт хэрэгжүүлэх үүднээс

Байгууллагын бодлого нь БОНБГҮ-ний заагчийг сонгоход чиглэх ба түүнийг БОНБГҮ-ний заагч (ажиллагааны гүйцэтгэл, удирдлагын гүйцэтгэл) болон байгаль орчны нөхцөл байдлын заагчийг сонгоход хэрэглэнэ. БОНБГҮ-ний заагчийг сонгох зарим жишээг А.3.1, А.3.2-д үзүүлсэн.

Байгал орчны зарим асуудал нь цогц байдалтай байх ба энэ нь гүйцэтгэлд хамаарах асуудлыг үнэлэх БОНБГҮ-ний заагч, байгаль орчны нөхцөл байдлын заагчийг хамтад нь сонгоход чухал ач холбогдолтой.

БОНБГҮ-ний заагчид зааснаар БОНБГ-ийн бүрэлдэхүүн хэсэг болох БОНБГ-ийн шалгуурт хүрэхэд чиглэсэн үйл ажиллагааны нөлөөг ойлгоход чухал мэдээллийг удирдлага сонгоно.

Байгууллага заагч бүр дэх төлөвлөсөн оролцогчдоос хамаарах өгөгдлөөс гарах БОНБГҮ-ний заагчийг сонгоно.

Практик зөвлөгөө ¹ 3.

Төлөвлөсөн оролцогчоос хамаарах өгөгдлөөс гаргасан байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээний заагчийг байгууллага хэрхэн сонгохыг харуулсан жишээ

Бохир усаа гол руу урсгадаг байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээний дараахь заагчийг сонговол зохино.

Практик зөвлөгөө 1 3. (Үргэлжлэл)

- Жилийн онцгой бохирдлын хэмжээ, дүн
(Боломжтой төлөвлөсөн оролцогч: орон нутгийн хэмжээнд);
- Хаягдал ус дахь бохирдлыг цэвэрлэх
(Боломжтой төлөвлөсөн оролцогч: хууль ба тохируулагч бүрэн эрхт этгээд);
- Нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бохирдлын хэмжээ
(Боломжтой төлөвлөсөн оролцогч: удирдлага болон хэрэглэгч);
- Цэвэрлэх технологи эсвэл ялгах ажиллагаанд зориулах хөрөнгө оруулалтаас хамаарах жилийн бохирдлын дүнгийн өөрчлөлт
(Боломжтой төлөвлөсөн оролцогч: удирдлага болон хөрөнгө оруулагч).

БОНБГ-д холбогдох бүс нутгийн, улс орны, дэлхий дахины заагч, дэмжиж буй хөгжлийг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын бус байгууллага, нийгмийн болон судалгаа, шинжилгээний байгууллага хөгжүүлнэ. Өгөгдөл цуглуулах, БОНБГ-ийн заагчийг сонгохдоо байгууллага түүнийг хангахуйц мөн чанар, нийцвэртэй мэдээлэл бүхий заагчийн талаар хэлэлцэхийг хүсч болно.

3.2.2.2 Удирдлагын гүйцэтгэлийн заагчийг сонгох

БОНБГ-нд удирдлага гэдэг ойлголтонд байгууллагын бүхий л түвшин дэх бодлого, хүн хүч, төлөвлөсөн үйл ажиллагаа, туршлага, дүрэм журам, байгаль орчны асуудалтай холбоо бүхий үйл ажиллагаа, шийдвэр зэргийг оруулна. Байгууллагын удирдлагын хүчин чармайлт, шийдвэр нь байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлд нөлөөлснөөр БОНБГ-ийг хийхэд дэмжлэг болно. (2-р зургыг үзнэ үү)

Удирдлагын гүйцэтгэлийн заагч нь байгууллагыг мэдээлэл, удирдлагын арга хэмжээ, сургалт, хуулийн шаардлага, хуваарилалт, үр дүнтэй ашиглалт, байгаль орчны удирдлагын өртөг зардал, чанартай бүтээгдэхүүн, баримт бичиг эсвэл засварлах ажиллагаа болон БОНБГ-д нөлөөлөх нөлөөллөөр хангана.

Удирдлагын гүйцэтгэлийн заагч нь БОНБГ-г сайжруулах удирдлагын хүчин чармайлт, шийдвэр, үйл ажиллагааг үнэлэхэд туслана.

Жишээлбэл удирдлагын гүйцэтгэлийн заагчийг дор дурдсанаар ашиглана:

- Байгаль орчны удирдлагын янз бүрийн хөтөлбөрийн үр нөлөө, хэрэгжилт;
- БОНБГ-ийн удирдлагын ажиллагаа болон байгаль орчны нөхцөл байдалд нөлөөлөх байгууллагын үйл ажиллагаа;
- Байгаль орчны удирдлагын амжилтанд нөлөөлөх удирдлагын хүчин чармайлт;
- Байгаль орчны удирдлагад боломжит (хийж дуусах) зорилго, зохицуулалт, шийдвэрлэх асуудал өөрчлөгдөх нөхцөл байдлыг багтаана;

MNS ISO 14031:2001

- Хуулийн зөвшөөрсөн болон норматив шаардлага;
- Санхүүгийн өртөг зардал, ашиг тус.

Нэмж хэлэхэд удирдлагын гүйцэтгэлийн шалгуур нь байгууллагад дараахь байдлаар тусална:

- Гүйцэтгэлийн өөрчлөлтийг урьдаас мэдэх;
- БОНБГ-ийн шалгууртай холбоо бүхий бодит гүйцэтгэлээс давуу байх үндсэн шалтгааныг тогтоох;
- Урьдчилан сэргийлэх ажиллагааны боломжийг тогтоох.

Олон улсын энэ стандартын А.4.2.2-д удирдлагын гүйцэтгэлийн шалгуурын талаархи жишээг зааж өгсөн.


3.2.2.3 Ажиллагааны гүйцэтгэлийн заагчийг сонгох

Байгууллагын ажиллагааны гүйцэтгэлийн заагч нь БОНБГ-ийг мэдээлэл бүхий удирдлагаар хангана. Ажиллагааны гүйцэтгэлийн заагчид хамаарах асуудал нь:

- Оролтын урсгал материал (боловсруулах, дахин боловсруулж ашиглах, эсвэл түүхий эд, байгалийн нөөц баялаг), эрчим хүч, үйлчилгээ;
- Байгууллагын үйл ажиллагаанд оролтын урсгалыг хэрэглэх;
- Байгууллагын тоног төхөөрөмж, техникийн үйлчилгээ болон зохион бүтээлт, угсралт, суурилуулалт (үүнд: үйл явдлын эвдрэлийн байдал, журамлаагүй ажиллагааг оруулна);
- Гаралтын урсгал: Байгууллагын ажиллагааны дүнгээр бий болсон бүтээгдэхүүн (Гол нэрсийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүнийг ашигласан болон дахин боловсруулж ашигласан бүтээгдэхүүн), үйлчилгээ, хаягдал (өөрөөр хэлбэл, хатуу, шингэн, хортой, хоргүй, дахин боловсруулж ашигласан, дахин ашигласан), бохирдол, дулааралт (агаар, ус, хөрс, ургамал, амьтан, чичирхийлэл, цацраг, гэрэлд нөлөөлөх дулааралт);
- Байгууллагын ажиллагааны дүнд гадагшлах гаралтын урсгалыг зөвшөөрөх.

Байгууллагын ажиллагааг 3-р зургаар мөн А.1-р зургаар нарийвчлан заасан нэмэлтээр тус тус үзүүлэв. Үйлдвэрлэлийн бодит бололцоо, бүтээгдэхүүн үйлчилгээний хангамж, үйл ажиллагааг нэмэгдүүлэх, эсвэл бүтээгдэхүүн үйлчилгээгээр хангах зэргийг БОНБГҮ-нд тооцож болно.

Олон улсын энэ стандартын А.4.3.2-д ажиллагааны гүйцэтгэлийн заагчийн жишээг зааж өгсөн.



3-р зураг- Байгууллагын үйл ажиллагаа(Ерөнхий тойм)

3.2.2.4 Байгаль орчны нөхцөл байдлын заагчийг сонгох

Байгаль орчны нөхцөл байдлын заагч нь орон нутгийн, бүс нутгийн, дэлхий дахины байгаль орчны нөхцөл байдлын тухай мэдээллээр хангана. Байгаль орчны нөхцөл байдлын заагч нь байгаль орчинд нөлөөлөх талаархи арга хэмжээ биш бөгөөд түүний заагчийн өөрчлөлт нь байгаль орчны нөхцөл байдал, байгууллагын ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний хооронд үүсэх харилцаанд хамаарал бүхий мэдээллээр бүрэн хангаж өгнө.

Байгууллага БОНБГ-ий байгаль орчны нөхцөл байдлын заагчийн ач холбогдлыг дэмжинэ. Байгаль орчны нөхцөл байдлын заагч нь байгууллагад дараахь байдлаар туслана:

- Байгаль орчинд ач холбогдолтой асуудлыг тогтоох ба удирдах;
- БОНБГ-ийн шалгуурын тохирсон үнэлгээ;
- БОНБГ-ийн шалгуурыг сонгох

(Удирдлагын гүйцэтгэлийн заагч болон ажиллагааны гүйцэтгэлийн заагч);

- Арга хэмжээний өөрчлөлтөд хамаарагдах үндсэн шугамыг тогтоох;
- Байгаль орчны хөтөлбөртэй холбоо бүхий байгаль орчны өөрчлөлтийг тодорхойлох;
- Байгаль орчны нөхцөл байдал, байгууллагын ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний хооронд үүсэх харилцан уялдаанд судалгаа хийх;
- Шаардлагатай арга хэмжээг тодорхойлох.

Байгаль орчны нөхцөл байдлын заагчийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх явдал бол орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын засгийн газрын агентлаг, засгийн газрын бус байгууллага, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн бизнесийн байгууллагын чухал асуудал байна.

Гэсэн хэдий ч байгууллага нь байгаль орчны зарим бүрэлдэхүүн хэсгийн нөхцөл байдал, тэдгээр үйл ажиллагааны хоорондын харилцааг тогтоосноор тэдний чадвар, сонирхол, хэрэгцээг тодорхойлж БОНБГ-ийг үнэлэхэд тусламж болж, байгаль орчны нөхцөл байдлын заагчийг сонгон хөгжүүлж болно.

MNS ISO 14031:2001

Байгууллага өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хянасны дүнд байгаль орчны онцлог нөхцлийг тогтоож, байгаль орчны нөхцлийн улмаас болж өөрчлөгдөх үйл ажиллагааны гүйцэтгэл болон удирдлагын хүчин чармайлтын дүнд БОНБГ-ийн заагчийг сонгохыг хүснэ.

Байгаль орчны нөхцөл байдлын заагчийн жишээг энэ стандартын А.4.4.2-д өгсөн.

Практик зөвлөгөө ¹ 4.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээний заагчийг сонгохтой уялдуулан байгаль орчинд гарах үр дүнг яаж тогтоохыг үзүүлсэн жишээ.

Жишээ 1.

Үйлчилгээний байгууллага байрласан нутаг дэвсгэрийн ойролцоох агаарын чанарыг тээврийн хэрэгслийн мотороос ялгарах бохирдлыг бууруулах зорилгод нийцсэн БОНБГҮ-ний заагчийг сонгоход агаарын чанарын тухай мэдээллийг ашиглан мэдэж болно.

Практик зөвлөгөө ¹ 4. (Үргэлжлэл)**Байгаль орчны нөхцөл байдлын заагч**

- Тээврийн хэрэгслийн мотороос гарах бохирдлыг бууруулах арга хэмжээ авах;

Ажиллагааны гүйцэтгэлийн заагч

- Түлшийг сонгож хэрэглэснээр тээврийн хэрэгслээс үүдэх дулааралтыг бууруулах;
- Түлшний зарцуулалтын тоо хэмжээ;
- Тээврийн хэрэгслийн моторт зарцуулах түлшний хүчин чадал;
- Тээврийн хэрэгслийн байнгын засвар;
- Байгаль орчны хяналтын технологи бүхий хэрэгслээр хангасан тээврийн хэрэгслийн тоо;

Удирдлагын гүйцэтгэлийн заагч

- Олон нийтийн мэдээлэл болон түүний ашиглалтыг дээшлүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ;
- Олон нийтийн мэдээллийн ашиглалтын тусын тулд ажиллагсдын сургах сургалтын цагийн тоо;
- Түлшний зарцуулалтыг бууруулах, тээврийн хэрэгслийг засварлах, түлшний чанарыг сайжруулах, сонгож хэрэглэх.

Жишээ 2.

Хэрэглээний усаа багасгах хэрэгтэй газар зүйн бүс дэх байгууллага усны өөрчлөгдөх арга хэмжээтэй холбоо бүхий БОНБГҮ-ний заагчийг сонгох ба сонгоход дараахь мэдээлэл хэрэгтэй.

Байгаль орчны нөхцөл байдлын заагч:

- Хөрсний усны төвшин;
- Дүүргэлтийн хувь;

Үйл ажиллагааны нөхцөл байдлын заагч:

- Өдөрт хэрэглэх усны хэмжээ;
- Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэх усны хэмжээ;


Удирдлагын гүйцэтгэлийн заагч:

- Ус хэмнэхэд зориулсан судалгааны аргад зарцуулах мөнгөн хөрөнгийн хэмжээ.

3.3 Өгөгдөл болон мэдээллийг хэрэглэх (Хий)

3.3.1 Ерөнхий тойм

4-р зурагт БОНБГ-ийг үнэлэхтэй холбоотой мэдээлэл, өгөгдлийг хэрэглэх үе шатыг үзүүлэв. Эдгээр үе шатыг 3.3.2 ба 3.3.5-д зааж өгсөн.



4-р зураг-Дэд бүлэг 3.3

3.3.2 Өгөгдөл цуглуулах

Байгууллага БОНБГҮ-ний заагчтай холбогдол бүхий тооцоонд шаардлагатай оролтод хамаарах энгийн өгөгдлийг цуглуулж ашиглана.

БОНБГҮ-ний төлөвлөлтөд хамаарах холбогдох өгөгдлийн эх сурвалжийг ашиглахаар системтэй цуглуулна. Өгөгдөл цуглуулах журмыг үнэн зөв, найдвартай

өгөгдлөөр батлана. Энэ нь нарийн судалгаа хийсэн нийгмийн болон аюулгүй байдлын баталгаатай салбарт хамаарна. Өгөгдөл цуглуулах журамд өгөгдөл мэдээллийг тогтоох, түүний жагсаалт, хадгалалт, буцаах, сэргээх дараалал багтана. Байгууллага өөрийн өгөгдөл эсвэл бусад эх сурвалжаас авсан өгөгдлийг ашиглана. Өгөгдлийг дараахь байдлаар цуглуулна:

- Хянах, арга хэмжээ авах;
- Дотоод шинжилгээ, ажиглалт;
- Зохицуулах тайлан;
- Тооцооны болон үйлдвэрлэлийн мэдээ;
- Санхүүгийн болон тооцооны тайлан мэдээ;
- Бусад мэдээ;
- Байгаль орчны шинжилгээ, аудит, эсвэл үнэлгээний тайлан;
- Байгаль орчны сургалтын бүртгэл;
- Шинжлэх ухааны тайлан, судалгаа;
- Засгийн газрын агентлаг, академи, засгийн газрын бус байгууллага;
- Нийлүүлэгч ба хамтран гэрээлэгч;
- Хэрэглэгч ба сонирхогч тал;
- Бизнесийн холбоо.

3.3.3 Өгөгдлийг хувиргах, дүн шинжилгээ хийх

Цуглуулсан өгөгдлийг байгууллагын БОНБГ-ийн заагчаар илэрхийлсэн БОНБГ-д үзүүлсэн мэдээлэл рүү хувиргаж, дүн шинжилгээ хийнэ. Үүний дүнд үнэн бодитой цуглуулсан өгөгдөл нь чухал ач холбогдолтой болно.

Өгөгдлийн шинжилгээнд өгөгдлийн чанар, баталгаа, хангалттай байдал, шаардлагатай бол үйлдвэрийн талаархи чухал мэдээлэл багтана.

Байгууллагын БОНБГ-нд өгөгдсөн мэдээлэл нь хэрэглэх тооцоо, сайн үнэлгээ, аюулгүй арга, техник график, жагсаалт, цуглуулалт, нөлөөллөөр хэрэгжинэ.

3.3.4 Мэдээллийг үнэлэх

Мэдээлэл нь шинжилгээ хийгдсэн өгөгдлөөс гарах бөгөөд түүнийг байгаль орчны нөхцлийн заагч болон БОНБГ-ийн заагчаар тоогоор илэрхийлэх ба БОНБГ-ийн шалгууртай харьцуулна. Энэ харьцуулалт нь БОНБГ-ийн үйл ажиллагаа болон дутагдлыг заана. Эдгээр харьцуулалт нь БОНБГ-ийн шалгуур байх эсэхийг ойлгоход ашигтай. БОНБГ-д заасан мэдээлэл болон харьцуулалтын үр дүнд

MNS ISO 14031:2001

БОНБГ-ийн түвшинд дэмжлэг үзүүлэх, сайжруулахад удирдлагын үйл ажиллагаанд тус үзүүлэх, мөн удирдлагад тайлагнах болно.

3.3.5 Тайлагнах ба харилцан мэдээлэх

3.3.5.1 Ерөнхий заавар

БОНБГ-ийг тайлагнах, харилцан мэдээлэх нь тухайн байгууллагыг түүний гүйцэтгэлийг тодорхойлох ашигтай мэдээллээр хангана. Мэдээллийг байгууллага дотроо болон гадны сонирхогч талд тайлагнах, мэдээлэх ба энэ нь удирдлагын үнэлгээ, түүнд оролцогчдод чухал. БОНБГ-ийг тайлагнах, харилцан мэдээлэхийн ашиг тусыг дараахь байдлаар харуулж болно:

- БОНБГ-ийн шалгуурт хүрэхэд байгууллагад туслах;
- Байгаль орчны бодлого, БОНБГ-ийн шалгуур, түүнд яаж хүрэх талаархи байгууллагын харилцан яриа, мэдлэгийг нэмэгдүүлэх;
- Байгууллагын үүрэг, хариуцлага, БОНБГ-ийг сайжруулах талаархи амлалт ба хүчин чармайлтыг бодитойгоор харуулах;
- Байгууллагыг байгаль орчны холбогдолтой асуулт, хариуцах арга механизмаар хангах.

3.3.5.2 Дотооддоо тайлагнах ба харилцан мэдээлэх

Удирдлага нь байгууллагын хэмжээнд БОНБГ-г цагаа олсон, шаардлагатай ба тохирох мэдээллийг тодорхойлон батална.

Энэ нь байгууллагын БОНБГ-ийн шалгуур, болон түүнийг хариуцлагатай гүйцэтгэх ажиллагсад, гэрээ хийгчид болон холбогдох байгууллагад туслана. Тухайн байгууллагаас байгаль орчны удирдлагын тогтолцоонд дүн шинжилгээ хийхэд энэхүү мэдээллийг хэрэглэнэ.

Байгууллагын БОНБГ-д заасан мэдээллийн жишээг дор үзүүлэв:

- Байгууллагын БОНБГ-ийн чиг хандлага өөрөөр хэлбэл хаягдлыг бууруулах;
- Хууль тогтоомжийн болон норматив шаардлага;
- Бусад шаардлагад нийцүүлэн байгууллагыг баталгаажуулах;
- Өртөг зардал, санхүүгийн бусад асуудал;
- БОНБГ-ийг сайжруулах талаархи шаардлагатай зөвлөгөө.

3.3.5.3 Гадны байгууллагад тайлагнах ба харилцан мэдээлэх

Тухайн байгууллага гадны сонирхогч талд БОНБГ-д заасан мэдээллийг мэдээлэх, байгаль орчны албан ёсны тайлангийн үр дүнг шаардаж эсвэл сонгож болно. Байгууллагыг мэдээллээр хангах БОНБГҮ нь байгууллагын тайлан эсвэл гадаад оролцогчийн харилцан мэдээлэлд багтана. Салбарын тоо нь байгууллагын БОНБГ-д заасан мэдээллийг тайлагнахад байгууллагын шийдвэрт нөлөөлнө. Эдгээр салбарт түүний үйл ажиллагаа, харилцааг багтаасан сонирхогч талын

харилцаа холбоо бизнесийн чиглэлийг сайжруулах байгууллагын сонирхол багтана. Энэ харилцан мэдээлэл нь байгууллагын БОНБГ-ийн талаар үнэн зөв төсөөлөлтэй болгоно. Байгууллагын БОНБГ-д заасан мэдээлэл нь оролцогчдод зориулсан техникийн мэдлэгийн төвшнөөс хамаарч бие даасан байдалтай байж болно. Байгууллага гадаад харилцан мэдээлэл хийх, сонгосон аргыг харилцан мэдээлэх, тайлагнаснаар байгууллага болон сонирхогч талын хоорондын харилцан мэдээллийг дэмжинэ.

Практик зөвлөгөө ¹ 5

Байгууллагын гадны сонирхогч талд харилцан мэдээлэх, тайлагнах мэдээллийн жишээ:

- Байгаль орчны удирдлагын бүрэлдэхүүн хэсэг болох БОНБГ-ийн талаар байгууллагын үүргийг мэдээлэх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаа, тэдгээрийг тодорхойлох;
- БОНБГ-ийн заагч, холбогдох болон байгаль орчинд ач холбогдолтой асуудлыг мэдээлэх;
- БОНБГ-ийн шалгуурт холбогдох гүйцэтгэлийн талаархи мэдээлэл;
- БОНБГ-ээс үүдэх үйл ажиллагаа;
- БОНБГ болон байгаль орчны удирдлагын нөхцөл байдал нь байгууллагын амжилтад хүрэхэд дэмжлэг болж өгөх.

3.4 Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийг сайжруулахаар дүн шинжилгээ хийх (Шалга, хий, арга хэмжээ ав.)

Байгууллагын БОНБГ-г цаашид сайжруулах боломжийг тогтоох дараалсан дүн шинжилгээ хийнэ. Шинжилгээ бүр нь удирдлагын гүйцэтгэл, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад удирдлагын үйл ажиллагаанд тус дэм болно.

Байгууллагын БОНБГ-ийн дүн шинжилгээний үе шат болон түүний үр дүнд дор дурдсан тоймыг багтаана:

- Хүрэх ашиг тус, зохистой өртөг зардал;
- БОНБГ-ийн шалгуураар үзэх дэвшил;
- БОНБГ-ийн шалгуурыг илүү нийцүүлэх;
- БОНБГ-ийн үнэлгээний заагчийг сонгож, нийцүүлэх;
- Өгөгдлийн эх сурвалж, түүнийг цуглуулах арга, болон өгөгдлийн чанар.

Практик зөвлөгөө¹ 6. (Шалга, сайжруул)

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийг үнэлж, дүн шинжилгээ хийхэд туслах асуултын жишээ:

Байгууллагын БОНБГ-ийг үнэлэхэд шаардагдах асуулт:

- Байгууллагын БОНБГ-ийн арга хэмжээг өөрчлөхөд түүнд тохирох мэдээллээр хэрхэн хангах вэ?

Практик зөвлөгөө¹ 6. (Үргэлжлэл)

- Удирдлагыг ашигтай мэдээллээр хэрхэн хангах вэ;
- Төлөвлөгөөтэй холбогдуулан юуг хэрэгжүүлэн эхэлж байна вэ;
- Өгөгдлийн эх сурвалжийг хэрхэн нийцүүлэн ашиглаж, түүнийг яаж цуглуулах вэ;
- Цуглуулсан өгөгдлийг хэрхэн үнэлж, яаж дүн шинжилгээ хийх вэ?
- Тохирох арга хэмжээг яаж авах вэ?
- Байгууллагад холбогдох БОНБГ-ийн шалгуур ямар байх вэ?
- Байгууллагын БОНБГ-ийн мэдээллийн тухай тайлагнах, харилцан мэдээлэхэд зориулсан мэдээллээр хэрхэн хангах вэ?
- Сонирхогч талуудаас гаралт, оролтын урсгалыг хэрэглэх үеийн ач холбогдол, шаардлага гэж юу вэ?
- Байгууллагад ач холбогдолтой тал нь юу вэ?
- Байгууллага болон түүний хүрээлэл дэх өөрчлөлт гэж юу вэ?
- Байгаль орчны асуудлыг юунд чиглүүлэх вэ?
- Байгууллагын гүйцэтгэлтэй холбоотой арга хэмжээ гэж юу вэ?

Практик зөвлөгөө ¹ 7.

Байгууллагын байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулах талаар авах арга хэмжээний жишээ

- Өгөгдлийн чанар, найдвартай, хүчин төгөлдөр байдлыг сайжруулах;
- Шинжилгээ болон үнэлгээний боломжит байдлыг сайжруулах;
- БОНБГ-ийг үнэлэх талаар шинэ заагчийг эсвэл илүү сайн ашиглах заагчийг тогтоож хөгжүүлэх;
- БОНБГ-ийн үр дүнгийн хамрах хүрээг өөрчлөх.

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн
үнэлгээний нэмэлт заавар****А.1 Ерөнхий тойм**

Уг хавсралтанд энэ стандартад заасан нэмэлт ойлголтыг жишээ, үзүүлэн, хүснэгтээр харуулав. А.1-р хүснэгтэд үзүүлсэн хавсралт, үндсэн сэдвийн бүрэлдэхүүн хэсгийн хоорондын уялдааг үзнэ үү.

А.1-р хүснэгт - Хавсралт , үндсэн сэдвийн бүрэлдэхүүн хэсгийн хоорондын уялдаа

Үндсэн сэдэв	А хавсралтад хамаарах бүрэлдэхүүн хэсэг (элемент)
3.2 БОНБГҮ-г төлөвлөх (Төлөвлөх)	А.2 БОНБГҮ-н дэх сонирхогч талуудын үзэл бодлыг нэгтгэн боловсруулах заавар
3.2.2 БОНБГҮ-ний заагчийг сонгох	А.3 БОНБГҮ-ний заагчийг сонгох нэмэлт заавар А.3.1 БОНБГҮ-ний заагчийн сонголтын ач холбогдол А.3.2 БОНБГҮ-ний заагчийн сонголтын хандлагад зориулсан жишээ А.4 БОНБГҮ-ний заагчийн жишээ
3.2.2.2 Удирдлагын гүйцэтгэлийн заагчийг сонгох	А.4.2 Удирдлагын гүйцэтгэлийн заагч
3.2.2.3 Ажиллагааны гүйцэтгэлийн заагчийг сонгох	А.4.3 Ажиллагааны гүйцэтгэлийн заагч
3.2.2.4 Байгаль орчны нөхцөл байдлын заагчийг сонгох	А.4.4 Байгаль орчны нөхцөл байдлын заагч

А.2. Байгаль орчны нөхцөл байдлын гүйцэтгэлийн үнэлгээ дэх сонирхогч талуудын үзэл бодлыг нэгтгэн боловсруулах заавар

БОНБГҮ-г төлөвлөхдөө байгууллага нь сонирхогч талуудтай холбоотой мэдээллийг тайлбарлаж, адилтгаж үзнэ.

А.2.1 Сонирхогч талуудын чадавхи

Байгууллагатай харилцах янз бүрийн сонирхогч талууд, тэдгээрийн хувьцаа, БОНБГҮ-г төлөвлөхөд туслах чадавхи, сонирхолыг харилцан мэдээлэх, түүнийгээ хэрхэн илэрхийлэх чадавхи.

Сонирхогч талуудын жишээ:

- Удирдлагын төлөөлөл;
- Ажиллагсад;
- Хөрөнгө оруулагч, тэдгээрийн бодит чадавхи;
- Хэрэглэгч, нийлүүлэгч;
- Гэрээлэгч;
- Зээлийн байгууллага, даатгалын компани;
- Тохируулагч болон хуулийн байгууллага;
- Хөрш орнуудын болон бүс нутгийн харилцагч байгууллага;
- Мэдээллийн хэрэгслээр дамжуулах;
- Бизнесийн, гүйцэтгэгч болон удирдах, эрдэм шинжилгээний байгууллага;
- Байгаль орчны системийн байгууллага, хэрэглэгч, сонирхогчийн бүлэг, засгийн газрын бус бусад байгууллага;
- Олон нийтийн байгууллага.

Сонирхогч талуудын энэхүү жагсаалтыг зөвхөн үзүүлэнгээр үзүүлэв. Жагсаалтад үзүүлсэн сонирхогч зарим талууд нь бүх байгууллагатай холбоотой байна. Бусад талууд нь байгууллагын нөхцөл байдал, төлөв, байршлаас хамаарна.

A.2.2. Сонирхогч талуудын үзэл бодол, хэлэлцэх асуудал

Санхүүгийн сонирголоос хамаарах үр дүнд дараахь асуудлыг оруулна:

- Удирдлагын болон байгаль орчны холбогдолтой зардлын нийт хэмжээ;
- Байгаль орчны өмнөх болон одоогийн үүрэг хариуцлагаас хамаарах санхүүгийн үр нөлөө;
- Байгаль орчны талаархи эерэг санаачлага;
- БОНБГ-ийг сайжруулахтай холбогдсон хөрөнгө оруулалт;
- Байгаль орчны хэлэлцэх асуудлаас үүдэх худалдааны давуу тал;
- Байгаль орчны тухай хууль тогтоомжийг даган мөрдөх, үл даган мөрдөхтэй холбогдсон үйлчилгээний үнэ хөлс.

Байгаль орчны талаар сонирхогч, эсвэл олон нийтийн бодлогын хэрэгжүүлэлтээс хамаарах хэлэлцэх асуудал:

- Эрүүл мэнд, аюулгүй байдал;

MNS ISO 14031:2001

- Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд гарах байгаль орчны бодит болон ойлгомжтой эрсдэл;
- Амьдралд чанарын нөлөө (дуу чимээ, нэр хүнд, мэдэгдэх нөлөөлөл);
- Байгаль орчны асуудал, түүний талаархи санал, гомдол;
- Байгууллагын байгаль орчны талаархи үүрэг, даалгаврыг гүйцэтгэх чадварын нотолгоо;
- Байгаль орчны нөлөөлөл;
- Чиг хандлагыг оролцуулсан (дулаан ялгаруулалт, хаягдал) байгаль орчинд бий болох ачаалал;
- Биологийн төрөлжүүлэлт;
- Бохирдлын хэтрэх зааг, дэлхийн байгаль орчны бусад асуудал;
- Худалдаан дахь байгаль орчны нөлөө;
- Хууль тогтоомжийн зохицуулалт;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний холбогдолтой байгаль орчны үзүүлэлт;
- Байгаль орчны талаархи дагаж мөрдөх хууль тогтоомжийн шаардлага;
- Эх үүсвэрийн зарцуулалт.

А.2.3 Сонирхогч талуудын үзэл бодлыг нэгтгэн боловсруулах арга

Сонирхогч талуудын үзэл бодлыг нэгтгэн боловсруулах аргын жишээ

- Судалгаа шинжилгээ, асуулга;
- Ажиллагсдын санал;
- Хуралдаан, семинар;
- Иргэний зөвлөх хэсэг, олон нийтийн хуралдаан;
- Ярилцлага;
- Олон нийтийн мэдээллийн дүн шинжилгээ, дотоод хөтөлбөр, сонирхогч талуудын санаачлага;
- Зах зээлийн судалгаа;
- Хууль тогтоомжийн чиг хандлага, хэрэгжүүлэх арга зам;
- Зөвлөмжийн заавар, стандарт;

- Электрон мэдээллийн солилцоо;
- Үйлдвэрлэлд оролцох болон олон нийтийн сонирхогч бүлэг;
- Хөрш болон хууль тогтоомжийн байгууллага, хэрэглэгч нийлүүлэгчтэй шууд харилцах мэдээллийн чиглэл;
- Мэдээллийн хэрэгслээр дамжуулах мэдээлэл, олон нийтийн мэдээллийн бусад эх сурвалж.

Байгууллага сонирхогч талуудын нөхцөл байдал, үзүүлэлтийг авч хэлэлцэхдээ хяналттай, хяналтгүйгээр оролт, тэдгээрийн саналыг оролцуулсан аргыг хэрэглэж, сонгоно.

А.3 Байгаль орчинд нөлөөлөх нөхцөл байдлын гүйцэтгэлийн үнэлгээний заагчийг сонгох зааврын нэмэлт

А.3.1 Байгаль орчинд нөлөөлөх нөхцөл байдлын гүйцэтгэлийн үнэлгээний заагчийг сонгохын ач холбогдол

БОНБГҮ-ний заагчийг сонгосноор байгууллагад дараахь ач холбогдолтой байна:

- Байгууллагын байгаль орчны бодлогод нийцэх;
- Байгууллагын удирдлагын хүчин чармайлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, эсвэл байгаль орчны нөхцөл байдлыг ашиглах;
- Байгууллагын БОНБГ-ийн шалгууртай холбоо бүхий гүйцэтгэлийг үнэлэхэд ашигтай байх;
- Гадаад дотоодын сонирхогч талуудад ойлгомжтой, түүнтэй холбоо бүхий цагаа олсон арга хэмжээ, үр ашигтай хямд төлбөрийн үнэ хөлс;
- Хэрэглэхэд тохирох өгөгдлийн чанар, тоо хэмжээ, төрөл;
- Байгууллагын БОНБГ-ийн төлөөлөл;
- Байгууллагын БОНБГ-ийн хэрэглэх нэгжид тавих хэмжилт;
- Байгууллагын БОНБГ -ийн өөрчлөлтөд гарах уриа ба мэдрэмж;
- Байгууллагын БОНБГ-ийн ирээдүйн чиг хандлага, эсвэл нийтлэг мэдээллээр хангах.

БОНБГ-ийн заагч нь байгууллагад ашигтай байх бүх ач холбогдлыг зааж чадахгүй.

А.3.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээнд заагчийг сонгох аргын жишээ

А.3.2.1. Чиг хандлагын үр нөлөө, учир шалтгаан

MNS ISO 14031:2001

Тухайн байгууллага нь суурь асуудалд чиглүүлэх заагчийг хэрэгжүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөлтэй асуудлын учир шалтгааныг тогтоохыг хүсэж болно. Энэ нь эдгээр шинжилгээнд үндэслэсэн заагчийг сонгох, учир шалтгааныг тогтоож, түүнийг гүйцэтгэж болно. Жишээ нь: Байгууллагын үйл ажиллагааны дүнд их хэмжээний дулаан ялгарах нь урьдчилан сэргийлэх ажиллагааг тохиромжгүй хийх юм уу түүнд бага анхаарсантай холбоотой.

Иймээс тухайн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн заагчийг ашиглан өдөрт ялгаруулах дулааны хэмжээ, удирдлагын гүйцэтгэх заагчийг ашиглан урьдчилан сэргийлэх ажиллагааг олон дахин хийх, түүнд чиглэсэн хөрөнгө мөнгөний хэмжээ зэргийг сонгож болно. Урьдчилан сэргийлэх ажиллагааг тохиромжтой байдлаар олон дахин хийснээр байгууллагын дулаан ялгаруулах хэмжээ багасна.

А.3.2.2. Эрсдэлээс үүсэх хандлага

А.3.2.2.1 Ерөнхий зүйл

БОНБГ-ийн заагчийг үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоо бүхий удирдлагын эрсдэлийг хэлэлцсэний үндсэн дээр сонгож болно. Янз бүрийн эрсдэлээс үүсэх хандлагыг дараахь жишээгээр үзүүлж байна.

А.3.2.2.2. Боломжтой эрсдлээс үүсэх хандлага

Тухайн байгууллагын үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөлтэй боловч түүнийг явуулах боломжтой эрсдэлээс үүсэх хандлагыг орчны бохирдол бууруулахад илүү тохиромжтой байхаар чиглүүлнэ.

Удирдлагын боломжтой гүйцэтгэлийн заагч: Аюулгүй байдлын талаархи сургалт хийх нь ажиллагсдаас онцлог үйл явцыг таньж, сайжруулна.

А.3.2.2.3. Хүний эрүүл мэндийн эрсдлээс үүсэх хандлага

Тухайн байгууллагаас ажиллагсдын эрүүл мэндэд аюул учруулж болохуйц эрсдэлтэй материалыг тогтоож, түүний сөрөг нөлөөллийн талаар санаа тавьж ажиллана.

Ажиллагааны боломжтой гүйцэтгэлийн заагч: Байгууллагын үйл ажиллагаанаас үүсэх онцлог материалын тоо хэмжээ

А.3.2.2.4. Санхүүгийн эрсдлээс үүсэх хандлага

Тухайн байгууллага өндөр ач холбогдолтой өртөг зардал бүхий БОНБГ-д хамаарах түүний бүрэлдэхүүн хэсгийг тогтоож, БОНБГ-ийн заагчийг сонгон хэрэглэж болно. Боломжтой БОНБГ-ийн заагч:

- Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэсэн өндөр үнэтэй материалын өртөг;
- Байгууллагын үйл ажиллагаанд өргөн хэрэглэгддэг ижил төрлийн материалын тоо хэмжээ;
- Ижил төрлийн хаягдал материалыг дахин ашиглахтай холбогдсон өртөг зардал;
- Хаягдал дахь ижил төрлийн материалын хувь хэмжээ.

А.3.2.2.5.Хохиролтой эрсдлээс үүсэх хандлага

Тухайн байгууллага байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, байгууллагын чадавхи зэрэг байгаль орчны асуудлыг авч үзнэ. Удирдлагын гүйцэтгэлийн заагчийн жишээ: Байгууллагын хлорфлуорокарбонийг орлуулахад чиглэсэн хөрөнгө оруулалт.

А.3.2.3 “Амьдралын мөчлөг”-ийн хандлага

Байгууллага нь бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгийн үе шат, байгаль орчинд нөлөөлөх хор уршигтай асуудал, ялангуяа бүтээгдэхүүнтэй холбоотой оролт, гаралтын талаар анхаарч үзэхдээ заагчийг сонгоно.

Жишээ 1.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нэмэгдэж болох түлшний хүчин чадлыг тогтооно. Боломжтой БОНБГҮ-ний заагч нь бүтээгдэхүүнд хэрэглэх дулааны нэгжийн тоо, түлшний хүчин чадлыг өсгөхөд бүтээгдэхүүний зохион бүтээлтийн өөрчлөлтийн тоог заана.

Жишээ 2.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэх үед байгаль орчинд сөрөг нөлөөлөх асуудал гарах ба материалыг хэрхэн шинэчилж ашиглахыг тогтооно. Боломжтой БОНБГҮ-ний заагч нь нэгж бүтээгдэхүүнд байнга хэрэглэх шинэчлэх материалын тоо, түүнийг орлуулах боломжтой арга хэмжээг заана.

Жишээ 3.

Бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэхэд хэрэглэх бүтээгдэхүүний баглаа боодлыг эргүүлэн авах, дахин ашиглахад явуулах үйлдвэрлэлийг яаж явуулахыг тогтооно. Ажиллагааны гүйцэтгэлийн боломжит заагч нь материалыг тээвэрлэх, баглаа боодлыг эргүүлэн авах, дахин ашиглах үйл ажиллагааг заана.

Жишээ 4.

Дахин ашиглах, дахин боловсруулж ашиглаж болохгүй бүтээгдэхүүнийг тогтооно. Иймээс БОНБГ-ийн үнэлгээний боломжтой заагчийг доорхи байдлаар харуулна:

- Дахин ашиглах болон дахин боловсруулж ашиглах бүтээгдэхүүний хэсгийн хувь хэмжээ
- Дахин ашиглах болон дахин боловсруулан ашиглаж болохгүй бүтээгдэхүүний хувь хэмжээ, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд өөрчлөгдөх тоо

А.3.2.4. Хууль тогтоомж, зөвлөмжийн хандлага

Байгууллагын ажиллагаа нь хууль тогтоомжийн, зөвлөмжийн гүйцэтгэлийн шалгуурыг тогтоосон ажлын хүрээнд БОНБГҮ-ний заагчийг сонгоход төвлөрнө. Ихэнх тохиолдолд, гүйцэтгэлийн арга хэмжээ, түүнд хамаарах хэрэгцээт өгөгдлийг байгууллага цуглуулж, хэрэгжүүлнэ. Иймээс БОНБГҮ-ний заагчийн арга хэмжээнд ашиглах байгаль орчны бохирдлоос ялгарах дулаан эсвэл тогтоосон тоо хэмжээтэй тайланг шаардана. Ажиллагааны боломжит гүйцэтгэлийн заагч: Жилд ялгарах дулааны бохирдлын нийт тоо хэмжээ, жилд гарах бохирдлын давсан тоо хэмжээ

Байгууллагын зөвшөөрсөн анхны хууль тогтоомжид хамаарах БОНБГҮ-ний заагчийг сонгоно. Жишээ нь: байгууллага бохирдлоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхны хууль тогтоомжийн хэсгийг шаардах ба жилд хийх үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой арга замыг олохыг хүснэ.

А.4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээний заагчийн жишээ

А.4.1. Ерөнхий тойм

MNS ISO 14031:2001

Удирдлага нь үүнийг ажлын хэсгүүдийн ажлын үр дүн, заагчийг сонгоход туслах функцыг тогтооход хэрэглэнэ.

БОНБГҮ-ний заагчийн хэд хэдэн жишээг зөвхөн үзүүлэнгээр тайлбарлан үзүүлэв. Өгөгдсөн үзүүлэн, жишээнд байгууллага бүрд хэрхэн ашиглахыг дэлгэрэнгүй тайлбарласангүй. Байгууллагын бодлого, зорилго, бүтэц нь өөр хоорондоо адилгүй байна. Байгууллага бүр БОНБГ-ийн шалгуурт хүрэхэд чухал БОНБГҮ-ний заагчийг сонгоно. Доор өгөгдсөн жишээний ихэнхи нь хяналтанд хэрэглэж болох салбарын төрлийг үзүүлэнгээр үзүүлэх тоо, үр дүн, арга хэмжээг хянах хэлбэрээр илэрхийлэгдэнэ. Байгууллага нь удирдлагын мэдээллийн хэрэгцээг илүү ашигтай байлгахад БОНБГҮ-ний хэд хэдэн заагчийг хайх ба байгууллагын нөхцөл байдал, цагийн тоо, ажилчид, худалдааны нэгж хэсэг, бүтээгдэхүүний нэгж хэсэг, бусад хамаарах нөхцлийг илэрхийлэхэд ашиглана.

A.4.2. Удирдлагын гүйцэтгэлийн заагч

A.4.2.1. Ерөнхий тойм

БОНБГ-ийг сайжруулах удирдлагын хүчин чармайлт нь байгууллагын бодлого, хөтөлбөр, шаардлага бүхий тохирол, итгэл, санхүүгийн гүйцэтгэл, харилцаа холбоог багтаана. Байгаль орчинд сөрөг нөлөөтэй асуудлаас хамаарах БОНБГ-ийн шалгуурыг хэрэглэхэд дараахь хэд хэдэн жишээг сонгоно. Дэд бүлэгт өгөгдсөн байгууллагын удирдлагын хүчин чармайлтын арга хэмжээг сонгох удирдлагын гүйцэтгэлийн заагчийн жишээ

A.4.2.2. Удирдлагын гүйцэтгэлийн заагчийн жишээ

A.4.2.2.1. Бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх

Удирдлагын сонирхол нь байгууллагын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэж байвал удирдлагын боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Хүрэх зорилго, зорилтын тоо;
- Байгаль орчны бодлого, зорилгод хүрэх зохион байгуулалтын нэгжийн тоо;
- Практик ажиллагаа, удирдлагын талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэм хэмжээ;
- Бохирдлоос сэргийлэх талаар авах арга хэмжээний дүн;
- Байгаль орчны онцгой хариуцлага бүхий удирдлагын шатны тоо;
- Мэргэжлийн тодорхойлолтод байгаль орчны шаардлагыг тодорхойлсон ажилчдын тоо;
- Байгаль орчны хөтөлбөрт оролцогчдын тоо (жишээ: үзэл бодол, дахин боловсруулж ашиглах, цэвэрлэж эхлэх, бусад);
- Хөтөлбөрт оролцогчдын зөвшөөрөх нийт тоо, шагнах ажиллагсдын тоо;
- Сургалтад хамрагдах ажиллагсдын тоо;

- Сургалтын гэрээний тоо;
- Сургалтаар эзэмшсэн мэдлэгийн түвшин;
- Байгаль орчны асуудлыг хэрэгжүүлэх талаархи ажиллагсдын үзэл бодол;
- Байгаль орчны асуудлын талаархи ажиллагсдын судалгаа, тэдгээрийн үр дүн;
- Байгаль орчны талаархи нийлүүлэгч, гэрээлэгчийн тавьсан асуултын тоо;
- Байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, бүртгэхэд дэмжлэг болох гэрээ хийсэн үйлчилгээний тоо;
- Тодорхой төлөвлөгөө бүхий бүтээгдэхүүний тоо;
- Дахин ашигласан, дахин боловсруулж ашигласны дүнд бий болсон бүтээгдэхүүний тоо;
- Байгаль орчинд “аюултай” гэсэн танилцуулга бүхий бүтээгдэхүүний тоо.

A.4.2.2.2 Тохирол

Удирдлагын сонирхол тохирлын шаардлагад хүрэх удирдлагын тогтолцооны үр ашгийг үнэлэхэд чиглэж байвал боломжит удирдлагын гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Хууль тогтоомжийн нийцлийн хэм хэмжээ;
- Байгууллагын гэрээнд заасан шаардлага болон магадлалыг хангах үйлчилгээний тохирлын хэм хэмжээ;
- Байгаль орчны асуудлыг зөв тодорхойлох, хариуцах хугацаа;
- Шийдвэрлэсэн болон шийдвэрлээгүй үйл ажиллагааны тоо;
- Торгуулийн хэмжээ;
- Онцгой үйл ажиллагааны давтамжийн тоо (аудит);
- Төлөвлөлтийн эсрэг хийсэн аудитын тоо;
- Үечилсэн баримжаа бүхий аудитын тоо;
- Үйл ажиллагааны журмын дүн шинжилгээний давтамж;
- Онцгой ажиллагаа хийх тоо;
- Хийхээр төлөвлөсөн дасгалын хариу, онцгой бэлтгэлийн хувь хэмжээ.

A. 4.2.2.3. Санхүүгийн гүйцэтгэлийн хэлэлцэх асуудал

MNS ISO 14031:2001

Удирдлагын сонирхол нь санхүүгийн гүйцэтгэлийн хэлэлцэх асуудлыг БОНБГ-тэй холбон үнэлэхэд чиглэж байвал удирдлагын боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Бүтээгдэхүүн, үйл ажиллагааны байгаль орчны асуудалтай холбоотой өртөг зардал (үйл ажиллагааны ба хөрөнгийн);
- Байгаль орчны төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт;
- Хэрэглэх арга хэмжээ, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хаягдлыг дахин боловсруулсны дүнд гарах хэмнэлт;
- БОНБГ-ийн зорилгод тусгасан шинэ бүтээгдэхүүн, түүнээс үүсэх орлогын хэмжээ;
- Байгаль орчинд сөрөг нөлөөтэй асуудлыг хамруулсан төслийг хэрэгжүүлэх эрдэм шинжилгээний байгууллага, хэрэгжүүлэх сан;
- Байгууллагын санхүүгийн статусд нөлөөлөх материалтай байх байгаль орчны талаархи үүрэг хариуцлага.

А. 4.2.2.4. Нэгдмэл байдлын холбоо

Удирдлагын сонирхол нь байгаль орчны үр дүнд хамаатай бүс нутгийн харилцаан дахь хөтөлбөрийг үнэлэхэд чиглэж байвал боломжит удирдлагын гүйцэтгэлд дараахь зүйлс багтана:

- Байгаль орчинд хамаатай арга хэмжээнүүдийн тухай тайлбарын тоо;
- БОНБГ-ийн талаархи тайлангийн тоо;
- Харилцан мэдээллээр хангах материалын тоо, байгаль орчны талаархи боловсролын хөтөлбөрийн тоо;
- Байгаль орчны тайлангийн хуудасны тоо;
- Хөтөлбөрийн хуудасны тоо;
- Орон нутагт хамаарах үйл ажиллагааны явц;
- Орон нутгийн цэвэрлэгээ, дахин боловсруулалт хийх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх;
- Харилцан мэдээллийн шинжилгээ, судалгаанаас үүдэх үнэлгээ.

А.4.3. Ажиллагааны гүйцэтгэлийн заагч

А.4.3.1. Ерөнхий тойм

Энэ дэд бүлэгт өгөгдсөн ажиллагааны гүйцэтгэлийн заагчийн жишээг байгууллагын үйл ажиллагаан дахь БОНБГ-ийн арга хэмжээнд ашиглаж болно. Байгууллагын

үйл ажиллагааг байгууллагын төхөөрөмж, бодит үйл ажиллагаатай холбогдолтой оролт, гаралтад үндэслэсэн орон нутгийн байдлаар ангилна. Байгууллагын үйл ажиллагаанд бодит үйл ажиллагаа, төхөөрөмж багтах ба түүнчлэн тэдгээрийг хэрэгжүүлэх шийдвэрлэх асуудал багтана.


А.1-р зурагт энэ хандлагыг үзүүлэнгээр үзүүлэв.

А.4.3.2. Ажиллагааны гүйцэтгэлийн жишээ

А.4.3.2.1. Материал

Удирдлагын сонирхол нь БОНБГ-д хамаарах материал, түүнийг ашиглах болон түүний үйл ажиллагаанд чиглэгдэж байвал, ажиллагааны боломжит гүйцэтгэлд дараахь зүйлс багтана:

- Нэгж бүтээгдэхүүнд ашиглах материалын тоо хэмжээ;
- Материалыг дахин ашиглах, дахин боловсруулж ашиглах тоо;
- Нэгж бүтээгдэхүүнийг дахин ашиглахад савлах материалын тоо;
- Дахин ашиглах, дахин боловсруулж ашиглахад хэрэглэх нэмэлт материалын тоо;
- Үйлдвэрлэлийн явцад дахин ашиглах түүхий эд, материалын тоо;
- Нэгж бүтээгдэхүүнд хэрэглэх усны хэмжээ;
- Дахин ашигласан усны тоо хэмжээ;
- Үйлдвэрлэлийн явцад хортой материал хэрэглэсэн тоо хэмжээ.



А.1-р зураг – Байгууллагын үйл ажиллагаа (Нэмэлт нарийвчилсан)

А.4.3.2.2. Эрчим хүч

Удирдлагын сонирхол нь нийт эрчим хүч, ашигласан эрчим хүчний төрөл, эрчим хүчний үр ашиг, байгууллагын үйл ажиллагаанд хамаарах БОНБГ-д чиглэж байвал боломжит ажиллагааны гүйцэтгэлд дараахь зүйлс багтана:

- Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд эсвэл жилд ашигласан эрчим хүчний хэмжээ;
- Үйлчилгээ болон хэрэглэгчийн ашигласан эрчим хүчний хэмжээ;
- Ашигласан эрчим хүчний төрөл бүрийн хэмжээ;
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон үйл ажиллагааны явц дахь эрчим хүчний хэмжээ;
- Эрчим хүчний өөрчлөлтийн хэмжээ.

А.4.3.2.3. Байгууллагын үйл ажиллагааны холбогдолтой туслах үйлчилгээ

Байгууллагын удирдлагын сонирхол нь түүний үйл ажиллагаанд туслаж чадах үйлчилгээнээс хамаарах БОНБГ-д чиглэж байвал, ажиллагааны боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Гэрээт үйлчилгээ үзүүлэгчийн хэрэглэсэн хорт бүтээгдэхүүний тоо хэмжээ;
- Гэрээт үйлчилгээ үзүүлэгчийн хэрэглэсэн цэвэрлэх агентийн тоо;
- Гэрээт үйлчилгээ үзүүлэгчийн хэрэглэсэн хаягдлын төрлийн тоо.

А.4.3.2.4. Бодит үйл ажиллагаа болон төхөөрөмж

Удирдлагын сонирхол нь байгууллагын бодит үйл ажиллагаа болон төхөөрөмжид хамаарах БОНБГ-д чиглэж байвал, ажиллагааны боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Дахин ашиглах, дахин боловсруулж ашиглах бүрд хэрэглэх төхөөрөмжийн тоо;
- Жилд нэгж төхөөрөмжийн үйл ажиллагаанд зарцуулах цагийн тоо;
- Бий болох үр дүн эсвэл жилд гарах тогтсон дүрэм журмаас ангид үйл ажиллагаа (эвдрэл)-ний тоо;
- Үйлдвэрлэл явуулах зорилгоор ашиглах нийт талбайн хөрс;
- Нэгж дулаан хэрэглэн үйлдвэрлэлд ашиглах талбайн хөрс;
- Тээврийн хэрэгсэлд зарцуулах түлшний хэмжээ;
- Бохирдлыг бууруулах технологи бүхий тээврийн хэрэгсэлийн тоо;
- Жилд төхөөрөмжийг засварлах цагийн тоо.

А.4.3.2.5 Шийдвэрлэх, хэрэгжүүлэх

Удирдлагын сонирхол нь оролтыг хэрэгжүүлэх, түүний үр дүн дэх гаралтыг шийдвэрлэх, байгууллагын үйл ажиллагаанд хамаарах БОНБГ-д чиглэж байвал, ажиллагааны боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Тээврийн хэрэгсэлд зарцуулах түлшний хувь;

MNS ISO 14031:2001

- Өдөрт тээвэрлэх тээврийн тоо;
- Харилцан мэдээлэх бизнес аялалын тоо;
- Тээвэрлэлтийн зам дахь бизнес аялалын тоо.

A.4.3.2.6 Бүтээгдэхүүн

Удирдлагын сонирхол нь түүний бүтээгдэхүүн эсвэл бүтээгдэхүүнээс гарах (Жишээ нь: худалдаалах зорилгоор үйлдвэрлэсэн, хадгалсан материал, бусад гол бүтээгдэхүүн, үүнд: дахин ашиглах, дахин боловсруулж ашиглах материал) гүйцэтгэлд чиглэгдэж байвал, ажиллагааны боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Зах зээл дэх хортой бүтээгдэхүүний тоо;
- Дахин ашиглах болон дахин боловсруулж ашиглах бүтээгдэхүүний тоо;
- Дахин ашиглах болон дахин боловсруулж ашиглах бүтээгдэхүүний чадамжийн хувь хэмжээ;
- Гэмтэлтэй бүтээгдэхүүний тоо хэмжээ;
- Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түүнээс гарах нэгжийн тоо;
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэх эрчим хүч;
- Бүтээгдэхүүнд хэрэглэх;
- Байгаль орчинд хор учруулж болох танилцуулга бүхий бүтээгдэхүүний тоо.

A.4.3.2.7. Үйлчилгээний байгууллага

Хэрвээ байгууллага төрөл бүрийн үйлчилгээ явуулдаг, удирдлагын сонирхол нь үйлчилгээнд хамаарах БОНБГ-д чиглэж байвал ажиллагааны боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Нэгж талбайд цэвэрлэгээ хийх агентын тоо (Цэвэрлэх үйлчилгээний байгууллага);
- Түлш зарцуулалтын хэмжээ (Тээврийн үйлчилгээний байгууллага);
- Үйл ажиллагааг сайжруулахад зарцуулах зөвшөөрлийн тоо (Технологид зөвшөөрөл олгох байгууллага);
- Байгаль орчноос хамаарах үйл ажиллагааны эрсдэл, дампуурлын тоо (Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага);
- Бүтээгдэхүүн худалдах үйлчилгээнд хэрэглэх материалын тоо.

A.4.3.2.8. Хаягдал

Удирдлагын сонирхол нь түүний үйл ажиллагаанаас гарах хаягдлаас хамаарах БОНБГ-д чиглэж байвал, ажиллагааны боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Нэгж бүтээгдэхүүнээс эсвэл жилд гарах бүтээгдэхүүний тоо хэмжээ;
- Жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс гарах хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулж ашиглах, сөрөг нөлөөллийн тоо;
- Хаягдлын нийт хэмжээ;
- Хаягдлын нөөцөлсөн хэмжээ;
- Хаягдлын зөвшөөрөгдөх хэмжээ;
- Жилд дахин ашигласан материал, дахин ашигласан хаягдлын хэмжээ;
- Материалыг орлуулвал зохих хортой хаягдлын хэмжээ.

А.4.3.2.9. Дулааралт

Хэрвээ удирдлагын сонирхол нь түүний үйл ажиллагаанаас болж агаарт дулаан ялгарахтай холбогдуулан БОНБГ-д чиглэж байвал ажиллагааны боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Жилийн дулааралтын хэмжээ;
- Нэгж бүтээгдэхүүний бохирдлын хэмжээ;
- Агаар бохирдлын хэмжээ;
- Озоны давхаргыг нимгэрүүлэхэд чиглэсэн агаарт ялгарч буй чадавхийг бууруулах хэмжээ;
- Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөхүйц агаарын бохирдлын хэмжээ.

Удирдлагын сонирхол нь түүний үйл ажиллагаа, хөрс, усанд нөлөөлөх БОНБГ-д чиглэж байвал, үйл ажиллагааны боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Онцлог бүтээгдэхүүний жилд ялгарах хэмжээ;
- Нэгж бүтээгдэхүүнээс усанд хаягдах онцлог материалын хэмжээ;
- Эрчим хүчний хаягдлын ус бохирдуулах хэмжээ;
- Нэгж бүтээгдэхүүнээс гарах хөрсөнд шингэх материалын тоо;
- Хэрэглэгч, үйлчилгээнд нөлөөллийн хир хэмжээ.

MNS ISO 14031:2001

Удирдлагын сонирхол нь түүний үйл ажиллагааны дүнд ялгарах дулаанаас хамаарах БОНБГ-д чиглэж байвал ажиллагааны боломжит гүйцэтгэлд дараахь зүйлс багтана:

- Зарим байрлалд холбогдох дуу чимээ ;
- Цацраг ялгаруулалтын хэмжээ;
- Дулаан, чичирхийлэл, цацрагийн хэмжээ.

A.4.4. Байгаль орчны нөхцөл байдлын заагч

A.4.4.1. Ерөнхий тойм

Энэ дэд бүлэгт байгаль орчны нөхцөл байдлын заагчийн жишээг өгөв. БОНБГ-ийн заагчийг хэрэгжүүлэхэд орон нутгийн, бүс нутгийн, үндэсний, олон улсын функц, засгийн газрын агентлаг, засгийн газрын бус байгууллага, нийгмийн болон эрдэм шинжилгээний байгууллага бусад хувийн байгууллага оролцоно. Хөрөнгө оруулах, байгаль орчны стандарт болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэвлэлд мэдээлэх зорилгоор эдгээр агентлаг, байгууллага доорхи өгөгдөл болон мэдээллийг цуглуулна:

- Усны чанар, найрлага бүтэц;
- Бүс нутгийн агаарын чанар;
- Аюулд өртсөн төрөл зүйл;
- Байгалийн нөөц баялгийн хэмжээ, чанар;
- Далайн усны температур;
- Амьд организмийн эд эс дэх бохирдлыг цэвэрлэх;
- Озоны давхаргын нимгэрэлт;
- Уур амьсгалын өөрчлөлт;
- Бусад параметр

Энэ мэдээллийн зарим нь байгууллагын БОНБГУ-г хэрэгжүүлэхэд ач холбогдолтой байгаль орчны асуудлыг удирдах, онцгой үр дүнг заахад ашигтай байх байгаль орчны нөхцлийн заалтын хэлбэр болно. Орон нутгийн байгаль орчны зарим бүрэлдэхүүн хэсгийн нөхцөл, тэдгээрийн үйл ажиллагааны хоорондын харилцаа холбоог тогтоох зарим байгууллагыг тэдгээрийн байгаль орчны гүйцэтгэлийг үнэлэхэд тэдний үйл ажиллагаа, сонирхол, хэрэгцээг ашиглан байгаль орчны нөхцлийн заагчийг сонгоно.

A.4.4.2. Байгаль орчны нөхцөл байдлын заагчийн жишээ

A.4.4.2.1. Бүс нутгийн, үндэсний, дэлхийн хэмжээний байгаль орчны нөхцөл байдлын заагч

Удирдлагын сонирхол нь бүс нутаг, үндэсний, дэлхийн байгаль орчны нөхцөлд туслахад чиглэж байвал тухайн байгууллага засгийн газар, засгийн газрын бус байгууллага, нийгмийн болон эрдэм шинжилгээний байгууллагын хэрэгжүүлсэн, хөрөнгө оруулсан заагчийг ашиглана. Заагч бүрийн жишээнд озоны үе давхарга, дэлхийн температур, далайн усны бохирдлын хэмжээ багтана.

А.4.4.2.2. Орон нутгийн болон бүс нутгийн байгаль орчны нөхцөл байдлын гүйцэтгэл

Байгаль орчны нөхцөл байдлын заагчийн жишээнд агаар, ус, хөрс, ургамал, амьтны аймаг, хүн төрөлхтөн, мөн гоо зүй, соёл орно.

а) Агаар

Удирдлагын сонирхол нь орон нутгийн болон бүс нутгийн агаарын талаархи мэдээлэлд чиглэж байвал байгаль орчны нөхцөл байдлын боломжит гүйцэтгэлийн заагчид дараахь зүйлс багтана:

- Хяналтын сонгосон байрлал дахь орчны агаарын бохирдлыг бууруулах;
- Орчны агаарын температур;
- Байгууллагын нөхцөл байдлын агаарын дээд, доод түвшин;
- Бүс нутаг дахь фотохимийн үр дүнгийн нөлөөлөл;
- Байгууллагын нөхцөл дэх дуу чимээний түвшин;
- Байгууллагын нөхцөл байдлаас үүсэх түүний нэр хүнд

Жишээ

А) Онцгой байрлал

Үйлдвэрлэл явуулж болохгүй газар байрласан байгууллага агаарт ялгарах дулааны хэмжээг хянах заалтанд үндэслэн оршин байгаа газрынхаа агаарт ялгарах дулааныг хянаж байх хэрэгтэй.

Б) Байгаль орчны нөхцөл байдлын заагчид хамаарах боломж

Байгууллагын нөхцөл байдлаас үүсэх түүний нэр хүнд

б) Ус

Удирдлагын сонирхол нь гүний болон хөрсний ус түүнчлэн бүс нутгийн болон орон нутгийн гол мөрний усны тухай мэдээлэлд чиглэж байвал байгаль орчны нөхцөл байдлын боломжит заагчид дараахь зүйлс багтана:

- Гүний болон хөрсний усны бохирдлыг бууруулах;
- Бохир усны улмаас голын усны дээд, доод бохирдол;
- Усанд ууссан хүчилтөрөгч;
- Байгууллагын нөхцөлд ойролцоо хөрсний усны температур;
- Хөрсний усны төвшний өөрчлөлт;
- Нэг литр усан дахь бактерийн тоо.

MNS ISO 14031:2001

Жишээ

А) Онцгой байрлал

Орон нутгийн захиргаа ургамал тарихад урсгал усыг хэрэглэснээр эрүүл мэндэд эрсдэлтэй байх эсэхийг тогтоохдоо урсгал усны дээд, доод түвшинд байх бактерийн тоог хянана.

Б) Байгаль орчны нөхцөл байдлын заагчид хамаарах боломж

Нэг литр усанд агуулагдах бактерийн тоо

с)Хөрс

Хэрэв удирдлагын сонирхол нь бүс нутгийн болон орон нутгийн хөрсний талаархи мэдээлэлд чиглэж байвал байгаль орчны нөхцөл байдлын боломжит заагчид дараахь зүйлс багтана:

- Байгууллагыг байршуулах сонгосон талбайн хөрсний тэжээллэг байдлыг бууруулах;
- Орон нутгийн сэргээгдэх талбай;
- Нутаг дэвсгэр дэх хөрсний нуралт, нойтон хөрстэй талбай;
- Нутаг дэвсгэр дэх шимгүй талбай;
- Нутаг дэвсгэр дэх талбайг хамгаалах;
- Нутаг дэвсгэр дэх хөрсний дээд хэсгийн элэгдэл.

Жишээ

А)Онцгой байрлал

Байгууллага хөрсөн дэх хохиролын талаар арга хэмжээ авна.

Б) Байгаль орчны нөхцөл байдлын заагчид хамаарах боломж

Орон нутгийн талбайн хөрсний элэгдэл

d) Ургамлын аймаг

Удирдлагын сонирхол нь бүс нутгийн болон орон нутгийн ургамлын аймгийн амьдрах нөхцөлд чиглэж байвал байгаль орчны нөхцөл байдлын заагчид дараахь зүйлс багтана:

- Орон нутгийн болон бүс нутгийн ургамлын сангийн бохирдлыг бууруулах;
- Орчны нутаг дэвсгэр дэх талбайн ургацын гарц;
- Орчны нөхцөл байдлыг тодорхойлох ургамлын бохирдол;
- Нутаг дэвсгэр дэх байрлалын тоо;
- Нутаг дэвсгэр дэх ургамлын тоо хэмжээнд авах арга хэмжээ;
- Орон нутгийн нутаг дэвсгэр дэх ургамлын чанарт авах арга хэмжээ.

Жишээ

А) Онцгой байрлал

Байгууллага агаарт флорид агуулсан дулаан ялгаруулж байвал уг дулаанд хяналт тавих ажиллагааг сайжруулахдаа ойролцоо байрших ургамалд судалгаа явуулна.

Б) Байгаль орчны нөхцөлд хамаарах боломж

Орон нутгийн нутаг дэвсгэр дэх ургамлын чанарт тавих арга хэмжээ

е) Амьтны аймаг

Удирдлагын сонирхол нь орон нутгийн болон бүс нутгийн нутаг дэвсгэр дэх амьтны аймгийн амьдрах нөхцлийн талаархи мэдээлэлд чиглэж байвал байгаль орчны нөхцөл байдлын заагчид дараахь зүйлс багтана:

- Орон нутгийн болон бүс нутгийн нутаг дэвсгэр дэх амьтны аймгийн бохирдлыг бууруулах;
- Байгууллагын нөхцөл дэх амьтны төрөл зүйлийн бохирдол;
- Нутаг дэвсгэр дэх уугуул амьтны төрөл зүйлийн чанарт авах арга хэмжээ;
- Нутаг дэвсгэр дэх нийт амьтны төрөл зүйлийн тоо.

Жишээ

А) Онцгой байрлал

Хөрсний талаар үйл ажиллагаа явуулдаг компаниуд үйл ажиллагаа болон бүс нутгийн биологийн төрөл зүйлийн хоорондын уялдааг үнэлнэ.

Б) Байгаль орчны нөхцөл байдлын заагчид хамаарах боломж

Нутаг дэвсгэр дэх амьтны төрөл зүйлийн тоо

ф) Хүн төрөлхтөн

Удирдлагын сонирхол нь орон нутгийн болон бүс нутгийн нутаг дэвсгэр дэх хүн амын амьдрах орчны бохирдлын тухай асуудалд чиглэж байвал байгаль орчны нөхцөл байдлын боломжит заагчид дараахь зүйлс багтана:

- Бохирдлыг бууруулах өгөгдөл;
- Орон нутагт буюу бүс нутаг дахь тахал, өвчний талаар судлах, үйл ажиллагаа явуулах;
- Орон нутагт буюу бүс нутгийн хэмжээнд өсөн нэмэгдэж буй бохирдлыг бууруулах;
- Орон нутагт буюу бүс нутаг дахь бохирдлын хэмжээ;
- Орон нутагт үүсэх бохирдлын түвшин

Жишээ

А) Онцгой байрлал

Байгууллага нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ялгаралтаар орчныг бохирдуулах, дулааралтыг бууруулахад хяналт тавина

Б) Байгаль орчны нөхцөл байдлын заагчид хамаарах боломж

Үүсэх бохирдлын түвшин

г) Гоо зүй ба өв соёл

Удирдлагын сонирхол нь нутаг дэвсгэрийн байрлал, түүх, соёлд хор уршиг үзүүлэхүйц нөхцөл, гоо зүйн салбарын талаархи мэдээлэлд чиглэж байвал байгаль орчны нөхцөл байдлын заагчид дараахь зүйлс багтана:

- Мэдрэх бүтцийн талаархи нөхцлийн арга хэмжээ;

MNS ISO 14031:2001

- Байгууллагын ажиллах нөхцөлд ойр байх газар нутгийн ариун цэвэрт авах арга хэмжээ;

- Нутаг дэвсгэр дэх түүх, соёлын болон бусад барилгын хөрсний ариун цэвэрт тавих арга хэмжээ.

Жишээ

А) Онцгой байрлал

Байгууллага ойролцоо нутаг дэвсгэр дээр байрлах түүх, соёлын болон бусад барилгын орчим агаарт ялгарах дулааны нөлөөллийн талаар арга хэмжээ авна.

Б) Байгаль орчны нөхцөл байдлын заагч

Орон нутгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын болон бусад барилгын хөрсний ариун цэвэрт тавих арга хэмжээ

Ном зүй

ISO 14001:1996, Байгаль орчны удирдлагын тогтолцоо - Ерөнхий шаардлага, ашиглах журам

ISO 14004:1996, Байгаль орчны удирдлагын тогтолцоо - Зарчим, тогтолцоо, бүрдүүлэлтийн ерөнхий аргачлал

ISO 14010:1996, Байгаль орчны аудитын гарын авлага - Ерөнхий зарчмууд

ISO 14011:1996, Байгаль орчны аудитын гарын авлага - Аудитын үйл ажиллагаа - Байгаль орчны удирдлагын тогтолцооны аудит

ISO 14032:-¹⁾, Байгаль орчны удирдлага- Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийг үнэлэх жишээ

ISO 14040:1997, Байгаль орчны удирдлага- Бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгийн үнэлгээ - Бүтэц ба Зарчим

ISO 14041:1998, Байгаль орчны удирдлага - Бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгийн баталгаажуулалт. Зорилго, хамрах хүрээг тодорхойлох, шинжилгээний цэс

ISO 14042:-¹⁾, Байгаль орчны удирдлага - Бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгийн үнэлгээ - Бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

ISO 14043:-¹⁾, Байгаль орчны удирдлага- Бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгийн үнэлгээ- Бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгийн тайлбар

ISO 14050:1998, Байгаль орчны удирдлага-Тайлбар толь